

**Нислэгийн цаг уурын төвийн
2019 оны 06 дугаар сард хийсэн ажлын тайлан**

2019.06.24

Зорилт:

Нислэгт цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх, нислэгийн зөрчил саатлын тоог бууруулах, албан хаагчдын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилт тавин ажилласан. Төвийн 2019 оны 6 дугаар сарын ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 06 дугаар сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ 212, урт хугацааны урьдчилсан мэдээ 122, районы урьдчилсан мэдээ 211, угталтын урьдчилсан мэдээ 139, өндрийн салхины урьдчилсан мэдээ 240, аэродромын урьдчилсан мэдээ 60, SIGMET 66, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 206, Тосонцэнгэл нисэх буудал орчмын TAF 64, Ханбумбат нисэх буудал орчмын TAF 153, Овоот нисэх буудал орчмын TAF 22, бусад нисэх буудал орчмын урьдчилсан мэдээ 32 удаа тус тус гаргаж, олон улсын 935, орон нутгийн 653, онцгой ба тусгай үүргийн 13 нислэгийг 396 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын төрөл бүрийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Хэрэглэгчдийн хүсэлтээр цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахимаар өгч байна. Төв орон нутгийн 5708 бодит мэдээ, 2043 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 6 дугаар сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх систем /WAFS/-ийн бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 0,27%-иар буурсан, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 1.29%-иар өссөн тус тус үзүүлэлттэй байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын байдлаас шалтгаалсан нислэгийн саатлын судалгаа: 6 дугаар сард нийт 62 саатал гарсан байна. Үүнд: таарсан 51, таараагүй урьдчилсан мэдээ 11.

Нислэгийн саатлыг үзэгдэл элементээр нь үзүүлвэл: Баруун хойдын салхитайгаас 20 нислэгийн гарсан бөгөөд урьдчилсан мэдээ таарсан 19, таараагүй 1, Зүүн өмнөдийн салхитайгаас 42 нислэг саатсанаас таарсан 32 таараагүй 10.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын бодит ажиглалтын мэдээ-1468, Уур амьсгалын ажиглалт-250, харьцуулсан ажиглалт-23, аюул-7, агаар-1, сарын дундаж мэдээ-4 удаа зохиосон.

Орон нутагт:

Олон улс болон орон нутгийн агаарын шугамд нислэг үйлдсэн үндсэн буудлын 418, бэлтгэл буудлын 835 нислэгт, нислэгийн чиглэлийн урьдчилсан /НИ-5/ мэдээ 184, угталтын урьдчилсан мэдээ 25, буудал орчмын бодит мэдээ 3733, буудал орчмын урьдчилсан мэдээ 1356, районы урьдчилсан мэдээ 533, аэродромын урьдчилсан мэдээ 337, зурвасын гадаргын байдлын мэдээг 10 дамжуулж үйлчилсэн.

Орон нутагт цаг агаараас шалтгаалсан 14 нислэгийн саатал гарсан бөгөөд Ханбумбат нисэх буудалд салхитай шороон шуургатай хүлээх нислэг хийсэн 1, Чойбалсан нисэх буудалд бороотой, салхитайгаас хүлээсэн 1, Булганаас – Хангал сум Тагтын хотгор, Эрдэнэтийн район 4 нислэг замын цаг агаар муугаас цуцалсан. Булган, Эрдэнэт, Дархан-Уул аймгийн Орхон сум, Тагтын хотгорын районы агаар муугаас, хэт халуун температуртайгаас хүлээсэн, цуцалсан 8 нислэг саатсан байна.

Бусад ажлын талаар:

- “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудалд үйлдэгдэх нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх түр журам” баталж албан хаагчдад танилцуулах сургалт явуулсан.
- Бэлтгэл ажлын хүрээнд шинэ нисэх буудлын цаг уурын алсын барааны харагдац болон үүлний доод суурийн өндрийг нүдэн баримжаагаар тодорхойлох батлагдсан тэмдэгтүүд, Төв аймгийн аюулгүйн бүсийн станц харуулуудыг сонгон баталгаажуулсан.
- 06 сарын 18-нд ДЦУБ-аас цахимаар ирсэн “Монгол улсын нислэгийн цаг уурын үйлчилгээг шинэчлэн сайжруулах төсөл” -ийн талаарх асуултуудын хариуг бэлтгэж, салхины хурд, чиглэл, алсын барааны харагдацын мэдээг арван жилээр эмхэтгэн, орчуулж явуулсан.
- 6 сарын 20, 27, 28-ны өдрүүдэд “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал”-ын цамхагийн 202 болон нисэх буудал дахь 104 тоот өрөөнүүдэд сүлжээ, тоног төхөөрөмжийн /радар/ хэвийн ажиллагааг шалгасан.
- 6 дугаар сарын 28-нд МИАТ ТӨХК-ийн “Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд”, хамтран ажиллах гэрээний дагуу Нислэгийн цаг уурын төвд аудит шалгалтыг явуулсан.
- 6 дугаар сарын 28-нд ЦУОШГ-ын “Архив, мэдээллийн сангийн хэлтэс”-ээс Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан ЦУОШГ-ын даргын баталсан төлөвлөгөөний хүрээнд урьдчилсан шалган туслах үзлэг шалтгалт явуулж, зөвлөмж өгсөн.

Сургалт дадлага, хурал, семинар:

Нэр	Албан тушаал	Ямар чиглэлээр сурсан	Хугацаа
Орон нутгийн 17 синоптик инженер хамрагдсан.	Орон нутгийн синоптик инженерүүд	Орон нутгийн синоптик инженерүүдийг дадлагажуулах, мэргэшүүлэх 120 цагийн сургалт	2019.05.27-2019.06.14
А.Баярмаа	Сүлжээ, мэдээлллийн сангийн инженер	Үндэсний мэдээлэл технологийн академид программ хангамж мэдээлэл технологийн 3 сарын сургалт	2019.03.05-2019.06.08
Ш.Аюушжав	Сүлжээ, мэдээлллийн сангийн инженер	Үндэсний мэдээлэл технологийн академид вэб мастер мэдээлэл технологийн 3 сарын сургалт	2019.03.05-2019.06.11
Б.Болормаа	МҮХ-ийн дарга	Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн төвд зохион байгуулагдсан APANPIRG-гийн MET/SG23 дэд группын хурал	2019.06.17-.2019.06.21
Н.Энхдалай	Гадаад харилцаа, төсөл хөтөлбөр, сургалт хариуцсан мэргэжилтэн	Авилгатай тэмцэх газрын олон нийтийн төвд “Авлигын эсрэг” 8 цагийн сургалт	2019.06.24
Л.Одгариг, Б.Тэмүүлэн	Ахлах синоптик инженер	Азийн бүсийн нисэхийн цаг уурын аюултай үзэгдэл, хамтын ажиллагаа сургалт, семинар, Цаг уурын тоон загварчлал ба синоптикийн сургалтуудад ахлах синоптик инженерүүд хамрагдагдаж байна.	2019.06.30-наас

Орон нутгийн УЦУОШТ-үүд болон нисэх буудлуудаас

Нэрс	Албан тушаал	Аймаг	Хугацаа
Ц.Лхагвасүрэн	Техникч	Өмнөговь аймгийн УЦУОШТ	2019.05.15-06.07
Х.Келгенбайн	Техникч	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ -өөс техникчээр ажиллах үйлдвэрлэлийн дадлага хийж байна.	2019.05.17-оос

5 сарын 27-оос 6 дугаар сарын 14-ны хооронд орон нутгийн синоптик инженерүүдийн анхан шатны сургалтыг зүхион байгуулж, ЦУОШГ-ын даргын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/166 дугаар тушаалаар мэргэшлийн үнэмлэх олгосон. Энэхүү сургалтад Завхан, Баянхонгор, Дундговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь, Архангай, Говьсүмбэр аймгуудын УЦУОШТ-ийн 16 ажилтан хамрагдсан.

Дүгнэлт:

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 6 дугаар сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.

Нислэгийн цаг уурын төвийн
Дотоод хяналт, чанарын хэсэг